



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Баруун-Урт СУМЫН  
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

2024.08.08 № 457  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр ( ..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.ДАВАА

Баруун-Урт сумын Монгол Ардын намын хорооны  
Тэргүүлэгчдийн хурлын 2024 оны 6 дугаар сарын 22-ны  
өдрийн 03 тоот тогтоолын хавсралт.



**БАРУУН-УРТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2024-2028 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН  
НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО**

**1.1. Орон сууц**

- 1.1.1 “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Баруун-Урт сумын иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэнэ.
- 1.1.2 Орон нутагт шинээр баригдаж буй орон сууцны төлөвлөлтөд ногоон байгууламж, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллана.
- 1.1.3 Хуучин орон сууцны байрнуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.


**1.2 Эрүүл мэнд**

- 1.2.1 Эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтлана.
- 1.2.2 Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгслээр хангана.
- 1.2.3 Шаардлагатай багуудад бүсчилсэн байдлаар эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулна.

**1.3 Боловсрол**

- 1.3.1 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.
- 1.3.2 Сургалтын байгууллагын суралцагч англи хэлийг эзэмших тэгш боломж бүрдүүлж, англи хэлний багшийг гадаад болон дотоодод мэргэжил дээшлүүлэх боломжоор хангана.
- 1.3.3 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 1.3.4 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

- 1.3.5 Баруун-Урт суманд шинээр ерөнхий боловсролын сургуулийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.
- 1.3.6 Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх "Сайн багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.7 Олон улс, улс, бүсийн түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжих урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



#### **1.4 Мэдлэг, ур чадвартай төгсөгчид**

- 1.4.1 Тэргүүлэх чиглэлтэй уялдсан ур чадвартай гагнуурчин, инженер техникийн мэргэжилтнийг улсын их, дээд сургууль, коллежид бэлтгэх бодлого баримтална.
- 1.4.2 Нээлттэй, ил тод, шударга байх зарчмыг баримтлан хөгжлийн тэргүүлэх чиглэлээр олгох дотоодын сургалтын тэтгэлэгийн сонголт, цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

#### **1.5 Нийгмийн баталгаа**

- 1.5.1 Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлийн 2 хувийг иргэн бүрийн нэрийн дансанд мөнгөжүүлэх ажлыг үргэлжлүүлж, цаашид хуримтлалын санд үүсгэх хувь хэмжээг үе шаттай хамтран ажиллах хэлбэрээр хэрэгжүүлнэ.

#### **1.6 Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн бодлого хүүхэд**

- 1.6.1 Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж, баг бүрд гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллыг сайжруулах.
- 1.6.2 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

#### **Өсвөр үе ба оюутнууд**

- 1.6.3 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.
- 1.6.4 Дунд сургуулиа төгсөж буй сурагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

#### **Залуучууд**

- 1.6.5 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 1.6.6 Төгсөгчдөд зориулан "Хийнгээ суръя- Орлого олъя - Хэмнэе" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.
- 1.6.7 Залуу үеийнхэний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн "Хөгжлийн хөтөч - Оюунлаг залуучууд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.6.8 Хүүхдийн сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлж “Залуу техникчдийн төв” байгуулна.
- 1.6.9 Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн бүхий “Хүүхэд залуучуудын парк” шинээр барьж ашиглалтанд оруулна.

### **Гэр бүл**

- 1.6.10 Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.
- 1.6.11 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.6.12 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй бодлогыг хөгжүүлнэ.
- 1.6.13 Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд бүрэн хамруулах, мал аж ахуйгаа эрхлэн хоршин амьдрахад таатай нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.6.14 0-2 насны хүүхэд харах үйлчилгээг дэмжинэ.

### **Ахмад настан**

- 1.6.15 Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, геронтологийн салбарыг бодлогоор дэмжиж “Ахмадын хөгжлийн төв”-ийн ажилгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- 1.6.16 Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцсэн байдлаар зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 1.6.17 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцлийг бүрдүүлнэ.

### **Малчид**

- 1.6.18 “Таван их наядын хөтөлбөр”-ийн хүрээнд малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг орон нутагт үргэлжлүүлнэ.
- 1.6.19 Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж, малын тоо бус чанарыг чухалчилна.
- 1.6.20 Зудын эрсдэлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлнэ.

### **Эхчүүд, эмэгтэйчүүд**

- 1.6.21 Эхчүүдэд зориулсан төрөлжсөн мэргэжлийн асрах үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцүүлэн хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 1.6.22 Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## **Эрэгтэйчүүд**

1.6.23 Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд “Аав, эрчүүд”, “Чанартай амьдрал-аавуудын оролцоо” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.6.24 Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг орон нутаг идвэхитэй хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

## **Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.6.25 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.6.26 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.6.27 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

## **Ажилтан**

1.6.28 Ажилтныг шударга үнэлэх, зохих цалин хөлсний хэмжээг тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажиллагчдад тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд Үйлдвэрчний эвлэлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.

## **Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд**

1.6.29 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.

1.6.30 “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулан зуучлах үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.6.31 Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.6.32 Зорилтот өрхүүдэд зориулсан түрээсийн орон байрны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## **1.7 Хөдөлмөр эрхлэлт**

1.7.1 Шинээр зохистой ажлын байр, өндөр технологийн шинэ ажлын байрыг бий болгох төлөвлөгөө баталж, ажилгүйдлийн түвшнийг тууштай бууруулах бодлого баримтлана.

1.7.2 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

## **1.8 Соёл**

- 1.8.1 Төр-иргэний хамтын ажиллагааны түншлэлд ~~үндэслэн~~ сумын хэмжээнд соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан, хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
- 1.8.2 Баруун-урт хотын түүх, соёлын дурсгалуудыг сурталчлан таниулах нэгдсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэнэ.

## **1.9 Спорт**

- 1.9.1 Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлнэ.
- 1.9.2 Баг тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.
- 1.9.3 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг байгуулна.
- 1.9.4. Аймаг орон нутгийнхаа нэрийг гаргаж бүс, улс, тив дэлхийд өрсөлдөж амжилт гаргаж буй тамирчдаа урамшуулан дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.9.6. Баруун-Урт хотод дугуйн замыг ашиглалтанд оруулж “Дугуйтай хот” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО**

### **2.1 “Шинэ хоршоо” хөдөлгөөн- Хөдөөгийн сэргэлт**

- 2.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.
- 2.1.1 Хоршоодод олгож буй хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх бодлого баримтлана.
- 2.1.2 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг дэмжинэ.
- 2.1.3 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэгийг оновчтой болгоно.
- 2.1.4 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг сурталчилж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэнийг чадавхижуулна.
- 2.1.5 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

### **Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл**

- 2.1.6 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.
- 2.1.7 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон салбар болгон хөгжүүлнэ.
- 2.1.8 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.
- 2.1.9 Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлана.
- 2.1.10 Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг байгуулна.
- 2.1.11 Малын тэжээлийн үйлдвэрийг байгуулах бодлого баримталж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 2.1.12 Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ.
- 2.1.13 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.1.14 Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 2.1.18. Үйлдвэр технологийн паркийг сэргээн хөгжүүлэх замаар 500 ажлын байр шинээр бий болгоно.


#### **Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт**

- 2.1.15 Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хагас боловсруулах, инновац, технологи шингэсэн “ЦАГААН АЛТ” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

#### **Эрүүл хүнс**

- 2.1.16 Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.17 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.


2.1.18 Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулна. Баруун-Урт сумын Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.



## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ

### 3.1 Шинэ ажлын байр


- 3.1.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 3.1.2 Жижиг, дунд бизнесийг дэмжих зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулан үйл ажиллагааг нь хялбаршуулж, хүртээмжтэй, үр дүнтэй болгоно.
- 3.1.3 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
- 3.1.4 Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлэх бодлого баримтална.
- 3.1.5 Ажлын байрыг шинээр бий болгосон орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.6 Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.1.7 Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааг өргөжүүлнэ.



## ДӨРӨВ . ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

### 4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

- 4.1.1 Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 4.1.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 4.1.3 Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг “1+2” буюу гадаадад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.
- 4.1.4 Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын ипотекийн зээлийн бодлого баримтална.
- 4.1.5 Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 4.1.6 Төрийн үйлчилгээний албан хаагч нарт зориулсан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.1.7 Төрийн үйлчилгээний албанд анхлан орж буй болон олон жил ажилласан албан хаагчдын ажлын үр дүнг шударгаар үнэлж урамшуулдаг системийг Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажиллах хэлбэрээр бий болгоно.



## **ТАВ . ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН**

### **5.1 Үнэт баялаг ус**

- 5.1.1 Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.1.2 Хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангах төслийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.1.3 Үерийн болон шар усыг боож хөв цөөрөм байгуулж, газар тариалангийн болон мал аж ахуйн усжуулалтанд ашиглана.


### **5.2 Шар шороон шуурга**

- 5.2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд худаг, услалтын систем, арчилгаа тордолтын асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
- 5.2.2 Экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад үйл ажиллагаа, өөрийн хөрөнгөөр хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.2.3 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулан шийдвэрлэнэ.

### **5.3 Ногоон эдийн засгийн шилжилт**

- 5.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.3.2 Хог хаягдлыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлнэ.



## ЗУРГАА . ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 6.1 Баруун-Урт хотын хөгжил

- 6.1.1 Баруун Урт суманд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 6.1.2 Баруун-Урт сумын хэмжээнд дулааны станцын хүчин чадлыг өргөтгөн, дулаан хангамжийн системийг сайжруулах ажлыг үе шаттай үргэлжүүлнэ.
- 6.1.3 Зүүн баян- Сайншанд - Баруун-Урт - Хөөт чиглэлийн 454 км төмөр замын төслийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэн хамтран ажиллана.
- 6.1.4 Хотын гудамж, талбайг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.
- 6.1.5 Баруун-Урт сумыг бүрэн камержуулж, хяналтын нэгдсэн системд холбоно.
- 6.1.6 Газрын доорхи инженерийн шугам сүлжээний ашиглалтын байдалд иж бүрэн экспертийн шинжилгээ хийлгэж, шаардлагатай шугам сүлжээг шинэчилнэ.

## **ДОЛОО. ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХ**

### **7.1. Гамшгийн үеийн бэлэн байдал**

- 7.1.1 Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээллэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, радарын станц байгуулна.
- 7.1.2 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх сумын нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 7.1.3 Гамшиг, ослын үеийн бэлэн байдлыг орчин үеийн техник, технологиор бүрэн хангаж, гамшгийн үед аврах чадавхийг бэхжүүлнэ.